



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2020 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 2/08

Бодь

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2021-2024 оны үйл ажиллагааны чиглэл
батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “в”, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021-2024 оны үйл ажиллагааны чиглэлийг байгууллагын гүйцэтгэлийн жил бүрийн төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /М.Ган-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.АМАР-АМГАЛАН



1617081

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 2
дугаар хуралдааны 2/08 дугаар тогтоолын
хавсралт



ЖИНСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2021-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Нэг. Эрхэм зорилго

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг чадварлаг, нээлттэй ил тод болгон төлөвшүүлж иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд тулгуурлан орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх, ард түмний амьдарлыг дээшлүүлж ая тухтай ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлж орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад эрхэм зорилгоо чиглүүлнэ.

Хоёр. Алсын хараа

Иргэнээ сонсож оролцоог бүрэн хангасан чиглэл хүлээж чадахуйц Иргэн төвтэй нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг төлөвшүүлэн хөгжүүлснээр төрөлх нутгаа "Ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлсэн жишиг сум" болгон хөгжүүлэхэд алсын хараатай ажиллана.

Гурав. Үндсэн зорилтууд

Нутгийн өөрөө удирдах байгууллага болон түүний ажилтнууд энэхүү зорилтуудыг удирдлага болгон үйл ажиллагаа нь иргэнээ дээдэлсэн, ардчилсан эрх чөлөө, ил тод шударга, хариуцлагатай бүтээлчээр ажиллаж иргэдийн сэтгэл ханамж дүүрэн байх түвшинд хүргэх

3.1. Иргэнээ дээдэлсэн байх: Хуулийг чандлан сахиж, хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа мэргэжлийн ур чадвартай ажилтнуудыг бэлтгэн хэрэгжүүлж гүйцэтгэлийн удирдлага, үр дүнг хянаж иргэдээ дээдэлсэн төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж, иргэдийн эрх ашигт нийцүүлсэн тогтоол шийдвэр гаргаж, дотоодын хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.

3.2. Ардчилал, эрх чөлөөтэй ил тод байх: Бодлого боловсруулах шийдвэр гаргахад иргэд, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн санал санаачлага, оролцоог нэмэгдүүлж, нээлттэй ил тод шударга хариуцлагатай байхын зэрэгцээ бодитой үнэн зөв мэдээ мэдээллийг ашигладаг байх.

3.3. Хариуцлагатай байх: Гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтийг хангуулах, биелэлтийг шалгах, иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, өргөдөл санал гомдлыг шийдвэрлэх үндсэн үүргээ иргэдээрээ үнэлүүлэн хариуцлага хүлээх чадвартай байх.

Дөрөв. Зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж буй гадаад орчин, бодит нөхцөл байдалд тулгуурлан, дэвшүүлсэн эрхэм зорилгодоо хүрэх дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

4.1. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга

4.1.1. Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн хамт дараах асуудлыг хариуцаж зохицуулна.

4.1.2. Сумын ИТХ, Тэргүүлэгч, төлөөлөгчид хороо, түр хороог тус тус нэгдсэн удирдлагаар хангах.

4.1.3. Сумын эдийн засаг, нийгэм соёлын болон нийт салбарын хөгжлийн асуудлыг цогцоор авч нэгдсэн бодлогоор хяналт тавих.

4.1.4. Сумын ИТХ, Засаг даргын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж Хурлын бүрэн эрх, иргэдийн нийтлэг эрх ашгийг хөндсөн тулгамдсан асуудлыг бүх шатны Хурал, Засаг дарга хууль хяналтын болон бусад байгууллагуудтай хамтран зохицуулна.

4.1.5. Сумын төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтанд хяналт тавина.

4.1.6. Ажлын албаны төсвийн зарцуулалтанд хяналт тавьж, төсвийн мэдээг сар бүр авч дүгнэлт гаргана.

4.1.7. Орон нутгийн өмчийн бүрдүүлэлт зарцуулалтанд хяналт тавьж хөрөнгийн асуудлыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар шийдвэрлэх.

4.1.8. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нутаг дэвсгэрийн эдийн засаг нийгмийн талаар дэвшүүлсэн тухайн жилийн зорилтын биелэлтэнд хяналт тавьж биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулах.

4.1.9. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Улаан загалмайн анхан шатны хороо зэрэг төрийн дээд шатны байгууллагын шийдвэрээр хүлээлгэсэн сонгуулийн ажил үүргийг хариуцах.

4.1.10. Төлөөлөгчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхэд нь холбогдох газруудтай холбогдож туслах, төлөөлөгчдөөс байгууллага, албан тушаалтанд тавьсан санал, шаардлагын мөрөөр хийх ажлыг зохион байгуулж биелэлт үр дүнг нэгтгэн төлөөлөгчид болон ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж байх.

4.2. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид

4.2.1. Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн хамт дараах асуудлыг хариуцаж зохицуулна.

4.2.2. Хуралдааны чөлөөт цагт тасралтгүй үйл ажиллагаа явуулна. Сумын эдийн засаг нийгмийн хөгжлийн бодлогын тодорхойлсон асуудлууд болон едөр тутмын асуудлуудыг эрх хэмжээний хүрээнд хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.2.3. Хуралдааны бэлтгэл ажил сайтар ханган ажиллана. Хуралданаар хэлэлцүүлэх асуудлуудыг урьдчилан хэлэлцэж бодлого тодорхойлно.

4.3. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хороо

4.3.1. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан хороодын хуралдаанаар хэлэлцэн дүгнэлт оруулна.

4.3.2. Тусгайлсан чиг үүргийнхээ хүрээнд орон нутагт тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн ИТХ болон Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулна.

4.3.3. Чиг үүргийнхээ дагуу хяналт шалгалт хийж дүгнэлт гаргана.

4.3.4. ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаас гарсан тогтоол шийдвэр биелэлтийг хангах, хэрэгжүүлэх асуудалд хяналт тавина.

4.3.5. Цаг үеийн асуудлыг судалж санал дүгнэлт боловсруулж холбогдох арга хэмжээ авна.

4.4. Орон нутгийн боловсон хүчний бодлогыг шинэчлэх хүрээнд

4.4.1. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан тушаалтны ажлын байрны хэрэгцээ шаардлагыг шинэчлэн тодорхойлж түүнд чиглэсэн боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлнэ.

4.4.2. Эрүүл мэнд, соёл боловсролын байгууллагын үйл ажиллагааг дэмжин мэргэжилтэй чадварлаг боловсон хүчнээр хангах, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажиллах орчныг нь бүрдүүлэх, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах, байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэхэд анхаарч ажиллана.

4.4.3. Удирдах ажилтны удирдах арга барилыг сайжруулж манлайлал бий болгоно.

4.4.4. Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг удирдах хянах, үр дүнг үнэн зөв үнэлж дүгнэх урамшуулах тогтолцоог сайжруулна.

4.4.5. Мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, ажилтнуудын мэргэжлийн өндөр мэдлэг чадвар болон манлайллыг хангаж ажиллана.

4.4.6. Сургалт судалгааны бодлогыг өөрчилж шинэчилснээр шилдэг туршлага, арга зүйг сурч эзэмших, үйл ажиллагаанд нэвтрүүлэх явцад гарна. .

4.5. Материаллаг бааз, санхүүгийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр

4.5.1. ИТХ-ын байгууллага авто машинтай болж Хурлын дарга, тэргүүлэгчид, төлөөлөгчид ажлын алба албан үүргээ гүйцэтгэх, иргэд сонсогчидтой хүрч ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

4.5.2. ИТХ-ын хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдаан, иргэдийн хэлэлцүүлэг сургалт семинар зохион байгуулах, Иргэний танхимын үйл ажиллагааг эрчимжүүлж, ашиглана.

4.5.3. ИТХ-ын төсвийг төсөл, хөтөлбөр, стратегийн бодлого төлөвлөлтөнд тулгуурлан бодитой төлөвлөж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал болон тэтгэмж урамшил, сургалт семинар мэдээлэл сурталчилгааны зардлыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, иргэдэд ил тод нээлттэй мэдээлж зарцуулалтанд хяналт тавьж ажиллана.

Хүрэх үр дүн: Төлөөлөгч, иргэд болон төрийн үйлчилгээний байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулна.

4.6. ИТХ, НӨУБ-ын үр нөлөө, чанар хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр

4.6.1. НӨУБ-ын гүйцэтгэж байгаа ажилд гадны мэргэжилтэн, эрдэмтэн судлаачдыг татан оролцуулах.

4.6.2. Ард түмний өмнө тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, эрсдэлтэй асуудлыг бодитой тодорхойлж, НӨУБ-ын үйл ажиллагааг түүнд чиглүүлж ажиллах тогтолцоог бүрдүүлнэ.

4.6.3. Үйл ажиллагааны үр дүнд эдийн засгийн үр өгөөжийг тогтвортой нэмэгдүүлнэ.

4.6.4. Харилцагч байгууллага иргэдээс үр өгөөж, чанар хүртээмжийн талаар судалгаа мэдээлэл авч бодлого шийдвэртээ тусгах

Тав. НӨУБ-ын үйл ажиллагаа

5.1. Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд тодорхойлогдсон бүрэн эрхийн хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж буй гадаад, дотоод орчин бодит нөхцөл байдалд тулгуурлан дэвшүүлсэн эрхэм зорилгодоо хүрэх дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

5.1.1. Иргэний танхимын тогтмол үйл ажиллагаатай болгож сумын эдийн засаг нийгмийн хөгжлийн талаар тулгамдсан асуудлуудыг боловсруулж, шийдвэрлэх, хэрэгжүүлэхэд иргэд, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.

5.1.2. Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилго чиглэлийг тогтоож, түүнийг хэрэгжүүлэхэд НӨУБ-ын үйл ажиллагааг чиглүүлэн хэрэгжилтийг ханган үр дүнд хяналт тавьж ажиллах.

5.1.3. Нутгийн өөрөө удирдах байгууллагын шинэчлэлийн зорилтыг ханган хэрэгжүүлэх, хөрөнгө санхүү, боловсон хүчин, материаллаг хангамжийг сайжруулж, тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломж нөхцлийг бүрдүүлэн бүх шатны НӨУБ-ыг бэхжүүлэх, сумын ИТХ-ын хороод багийн Иргэдийн нийтийн хурлыг байнгын үйл ажиллагаатай болгоно.

5.1.4. Бүх шатны хурлын хуралдаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, гарч буй тогтоол, шийдвэрийг цахим хэлбэрт шилжүүлж биелэлтийг нь хангасан ил тод нээлттэй, үйл ажиллагаатай болно.

5.1.5. Иргэдийн санал бодлыг сонсох, хүлээн авах, хурлын шийдвэрт тусгах, гаргасан тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, нээлттэй хэлэлцүүлэг хийх, санал асуулга авах, боловсруулалт хийх зэрэг ажлыг зохион байгуулна.

5.1.6. Төлөөлөгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх, тойрогтоо ажиллах нөхцөл боломжоор хангах, сургалт семинарыг үе шаттайгаар зохион байгуулах

5.2. Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тогтвортой байдал, ард иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцлийг хангах

5.2.1. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх бодлого баримтлана.

5.2.2. Багийн Иргэдийн нийтийн хурлын үйл ажиллагааг идэвхжүүлж, арга зүйн туслалцаа үзүүлэх, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг,

нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэх нөхцөл боломж, чадавхи соёл боловсролыг сайжруулах ажлыг зохион байгуулна.

5.2.3. Төлөөллийн ардчилалыг шууд ардчилалтай хослуулан иргэдийн оролцоотой төсвийн менежментийг хэрэгжүүлж, төсвийн орлогын бүрдүүлэлт зарцуулалт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах орлогыг нэмэгдүүлэх, үр ашиггүй зардлыг бууруулах бодлого баримтлана.

5.2.4. Монголын үндэсний ёс заншлыг сэргээн дээдэлж, гэмт хэрэг зөрчилгүй овог, гэр бүл хамт олныг урамшуулан дэмжих, архигүй Монгол хүн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого баримтлана.

5.2.5. Боловсрол, эрүүл мэнд, соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, төр засаг иргэд, олон нийтийн оролцоо хамтын ажиллагааг идэвхижүүлэхэд хамтарч ажиллана.

5.2.6. Мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлэх, мал сүргийн бүтцийг бүс нутгийн онцлогт тохируулан шилж сонгох, малын үүлдэр угсааг сайжруулах ашиг шимийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарна.

5.2.7. Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдал, чанар эрүүл ахуйн нөхцөлд тавих хяналтыг сайжруулна.

5.2.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин бүрдүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд анхаарч бодлогоор дэмжинэ.

5.2.9. Сумын мал эмнэлэг үржлийн тасаг, хувийн мал эмнэлгүүдтэй хамтран ажиллаж малын эрүүл мэндийн үйлчилгээнд хяналт тавьж, тайланг хэлэлцэх.

5.2.10. Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал бүр Тэргүүлэгчдийн хуралдаанаар авч хэлэлцэж хяналт тавих.

Зургаа. Хүрэх үр дүн

Сумын ИТХ-ын хороодын үйл ажиллагааны зохион байгуулалтыг шинэчлэн байнгын ажиллагаатай хэлбэрт шилжүүлэх.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэн бодлого тодорхойлох, шийдвэрлэх, хэрэгжилтийг хангаж үр дүнг тооцдог тогтмол ажиллагааг бий болгоно. Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн иргэд сонгогчидтой ажиллах нөхцөл боломжийг бүрүүлж ИТХ-ын үйл ажиллагаанд тасралтгүй оролцох тогтолцоог бий болгож мэдээллийн цахим сүлжээг бүрдүүлнэ.